

ЦАГДААГИЙН БАЙГУУЛЛАГЫН ГЭМТ ХЭРГЭЭС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ АЖИЛД ХЭСГИЙН БАЙЦААГЧИЙН ЭЗЛЭХ БАЙР СУУРЬ

ROLE OF A POLICE INSPECTOR IN CRIME PREVENTION



Б.БАЯНМӨНХ

ХСИС-ийн Цагдаагийн сургуулийн Цагдаагийн эрх зүйн тэнхимийн дэд профессор, докторант, цагдаагийн хошууч

BAYANMUNKH B.

Assistant professor of Police Administrative Department, Police School Of Law Enforcement University, Ph.D student, Police major

Товч агуулга: Гэмт хэрэг бол нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд хэзээ ч устаж үгүй болохгүй, аль ч нийгэмд байсаар ирсэн түүхтэй. Түүний гаралтыг зөнд нь орхих бус, харин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй, үр дүнтэй хэлбэрээр явуулах хэрэгтэй. Ялангуяа нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжид, цагдаагийн байгууллагын нийт албыг төлөөлөн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувьд хэсгийн байцаагч нар, хамгийн их үүрэг, хариуцлага хүлээдэг.

Abstract: Crime is a negative social phenomena. There is a need to fight and prevent crime. A police inspector of territorial police forces has a major role in crime prevention.

Хүний нийгэм, үүсч хөгжсөн үеэсээ гэмт явдлын улмаас үүсэх хор аюултай нүүр тулан учирсаар ирсэн түүхтэй. Хүн төрөлхтөн гэмт явдлыг зөвхөн хатуу чанд ял шийтгэлийн хүчээр хориглон зогсоох боломжгүйг ухаарсан цагаас хойш, нийгмийн сөрөг үзэгдлийн хамгийн тод илрэл болсон гэмт явдлаас урьдчилан сэргийлэх тухай ойлголтыг бий болгожээ.¹

Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийгмийн арга хэмжээг чухам юунаас эхлэх, түүнийг хэрэгжүүлэх үндэслэл хэзээ илэрч байна гэдгийг тогтоох явдал чухал юм.

Эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх нийгмийн арга хэмжээний хэлбэрийг тодорхойлохдоо уг ажлыг зохион байгуулж хэрэгжүүлж эхлэх үе, нийгэмд харш илэрлийн мөн чанар, онцлог, түүнийг дахин давталтаас сэргийлэх зайлшгүй шаардлага зэргийг харгалзан үзэх нь зүйтэй юм.²

Гэмт хэрэгтэй тэмцэх үндсэн арга бол урьдчилан сэргийлэх ажлыг чанартай зохион байгуулах явдал юм. Өнөөдөр гэмт хэргийг гарсан хойно нь хөрөнгө мөнгө, хүч хэрэгсэл, цаг заваа зарцуулан байж илрүүлэх, шийдвэрлэхдээ биш, харин гарахаас нь өмнө аль болох урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг, эрх зүйн зөрчил гарах нөхцөл байдлуудыг арилгахад чиглэгдсэн арга хэмжээг иж бүрэн

¹ Г. Даштүдэв. "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй". УБ. 2007. 123 дахь тал

² Н. Жанцан. "Гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээ". УБ. 1986. 31 дэх тал

цогцолбороор нь явуулах нь чухал юм.

Энэ асуудлыг, цагдаагийн байгууллага дангаараа өөртөө хүлээгээд хэзээ ч амжилт олохгүй. Үүнд төрийн болон төрийн бус байгууллага, иргэдийн хамтын ажиллагааг жигд хангах, иргэд, олон нийтийн байгууллага, аж ахуйн нэгжийг төрийн албадлага, итгэлцлэл дээр тулгуурлан, үүрэг ролийг нэмэгдүүлэх, энэ ажилд идэвхитэй оролцсон аж ахуйн нэгж, байгууллагуудыг ажлын үр дүнгээс хамааран шагнал, урамшуулал олгох, төрөл бүрийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын төслийг санхүүжүүлж байх нь гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд онцгой ач холбогдолтой байх болно.

Хууль хамгаалах байгууллагуудын нэг чухал зорилт бол гэмт хэрэг нэг бүрийг илрүүлж, гэм буруутай этгээдэд зохих хариуцлагыг шударгаар оногдуулахын хамт гэмт хэрэг, зөрчил гарахад нөлөөлсөн шалтгааныг илрүүлж, цаг тухайд нь арилгуулах замаар гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг бүх аргаар зохиоход оршино.³

Цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь хууль зүйн уламжлал, шинэчлэл нэвт шингэсэн, үр өгөөжтэй байх шаардлагатай.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь эдийн засаг, соёл, ёс суртахуун, тухайн нийгмийн түүхэн тодорхой нөхцөл, хүмүүсийн аж амьдралын түвшин, хуулийн хэрэгжилт, улс төрийн удирдлагын чадвар зэрэг олон талын хамааралтай байдаг.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг хэвшмэл байдлаас гаргаж, бүх нийтээр анхаарал тавьдаг болгоход цагдаагийн байгууллага гол санаачлагч байвал зохистой юм.⁴

1992 онд Монгол Улсын Ерөнхийлөгчийн дэргэд нийгмийн дэг журам хангах түр зөвлөлийг, 1995 онд Засгийн газрын дэргэд тус тус байгуулж, 1996 оноос Засгийн газрын тухай хуулиар Хууль зүйн сайдад уг үүргийг хариуцуулж ирсэн нь тухайн үедээ улс оронд дэг журам тогтоох, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд ихээхэн ач холбогдолтой явдал байсан юм.

УИХ-аас 1997 оны 12 дугаар сарын 5-нд “Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийг батлан гаргасан нь энэ чиглэлээр хийх үйл ажиллагаанд ихээхэн түлхэц болсон юм. Уг хуулийн дагуу зохицуулах зөвлөлүүд нь гурван үе шаттайгаар үүрэг гүйцэтгэх болсон бөгөөд Монгол Улсын Ерөнхийлөгч 1998 онд 06, 2001 онд 25 дугаар зарлигаар Зохицуулах зөвлөлийн бүрэлдхүүн, ажиллах дүрмийг баталж ажиллуулж эхэлсэн бөгөөд зохицуулах бүх шатны зөвлөлүүд тодорхой үүрэг гүйцэтгэж, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг улам идэвхижүүлж, ялангуяа цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх албаны бүтэц, үйл ажиллагааг боловсронгуй болгоход ихээхэн анхаарсан байна.

Дээрх арга хэмжээний хүрээнд, цагдаагийн байгууллагад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх хэлтэс, төв орон нутагт гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилтны орон тоог баталж, зарим аймаг, хотод гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тасгийг байгуулж, эрх зүйн орчинг бүрдүүлж өгсөн байна.

Захиргааны урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь, албадах замаар гэмт хэрэг, захиргааны зөрчлөөс сэргийлэх, эрх зүйн эсрэг нөхцөл байдал бүрдүүлэхгүй байхад чиглэгддэг захиргааны албадлагын бие даасан анхдагч төрөл юм.⁵

³ Ж. Авхиа. Гэмт явдал, түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудал. УБ. 1997. 159 дэх тал

⁴ Н. Гаравсүрэн. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил ба Цагдаагийн байгууллага. УБ. 2002. 3 дахь тал

⁵ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 202 дахь тал

Өнөөдөр төрөөс гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн дэг журмыг сахиулах бодлогыг хэрэгжүүлэх хүрээнд цагдаагийн байгууллагын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг улам боловсронгуй болгож, нийгмийн хөгжлийн явцад үүсэн бий болж буй эрүүгийн болон хэв журмын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж, хуулиар хүлээсэн үүргээ нэр төртэй, чин шудрагаар биелүүлж ажиллахыг эрхэм зорилгоо болгон түүнд нийцсэн урт болон богино хэмжээний төлөвлөгөөг батлан хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа цаг үетэйгээ уялдуулан үе шаттайгаар зохион байгуулан хэрэгжүүлж байна.

Цагдаагийн байгууллага гэмт хэрэг илрүүлэх, таслан зогсоох, урьдчилан сэргийлэх үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхийн тулд дан ганц өөрсдийн алба хаагчдын хүчээр ажиллах бус энэ үүргээ хурдан шуурхай, чанартай гүйцэтгэхийн тулд иргэд оршин суугчид, аж ахуй нэгж байгууллагын хүчийг ашиглах явдал чухал юм.

Энэ ажлын хүрээнд гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх, гэмт хэрэг, зөрчлийн гаралтыг бууруулахад цагдаагийн байгууллага дэвшилтэд техник, технологийг ашиглах, урьдчилан сэргийлэх ажлын шинэлэг арга барилаар ажлыг зохион байгуулах явдал онцгой чухал үүрэгтэй байдаг учир урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөөг сайжруулах арга замыг эрэлхийлэх ажил өнөөгийн цагдаагийн байгууллагын үйл ажиллагаанд дутагдаж байна.

Цагдаагийн байгууллага нь гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний үр дүнг дээшлүүлэхэд ерөнхий болон тусгай арга хэмжээнүүдийн объектыг зөв сонгох, шийдвэрлэх асуудлын хүрээнд нарийн судалгаа хийх, субъектүүдийн хүч, нөөц, тэмцлийн арга хэлбэр, хэрэгслэлийг төвлөрүүлэх, нийгэм, эдийн засгийн хөгжлийн төлөв байдал, гэмт явдлын тухай мэдээ, мэдээллийг харьцуулсан дүн шинжилгээ хийх байдлаар урьдчилан сэргийлэх ажлыг хэрэгжүүлж байна.

Гэмт хэрэг гэдэг бол нийгмийн сөрөг үзэгдэл бөгөөд хэзээ ч устаж үгүй болохгүй аль ч нийгэмд байсаар ирсэн түүхтэй. Түүний гаралтыг зөнд нь орхих бус харин түүнтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг тасралтгүй үр дүнтэй хэлбэрээр явуулах ёстой бөгөөд ялангуяа нутаг дэвсгэрийн анхан шатны нэгжид, цагдаагийн байгууллагын нийт албадыг төлөөлөн үүрэг гүйцэтгэж байгаагийн хувьд хэсгийн байцаагч нар, хамгийн их үүрэг хариуцлага хүлээдэг.

Цагдаагийн төв байгууллага нь “Цагдаагийн албаны тухай хууль”⁶ -иар хүлээсэн үүргээ хэрэгжүүлэх ажлыг удирдлага, зохион байгуулалтаар хангах, үйл ажиллагаа явуулах эрх зүйн үндсийг бүрдүүлэх ажлыг эрхлэн явуулдаг бол нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллага, тэр дундаа цагдаагийн бүхий л урьдчилан сэргийлэх ажлын дийлэнхи хувийг дангаараа зохион байгуулан хэрэгжүүлдэг субъект бол хэсгийн байцаагч билээ.

Өнөөдөр хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, мэргэжил, арга зүйн чиглэлээр удирдан чиглүүлж байгаа алба бол Нийтийн хэв журам хамгаалах алба болно.

Цагдаагийн байгууллагын Нийтийн хэв журам хамгаалах алба нь, Монгол Улсын Үндсэн хууль⁷ болон бусад хууль тогтоомжийг амьдралд хэрэгжүүлэх, нийгмийн хэв журам, хууль ёсыг бэхжүүлэх үйл хэрэгт захиргааны үйл ажиллагааны бусад төрөлтэй харьцуулбал тэргүүлэх байр эзэлж, хуулиар хүлээсэн олон үүрэг гүйцэтгэхийн зэрэгцээ үлэмж хэмжээний хүч хэрэгслийг өөртөө нэгтгэсэн

⁶ Төрийн мэдээлэл. 2013. №29

⁷ Төрийн мэдээлэл. 1992. №1

байдгаараа ихээхэн онцлогтой юм.

Тус алба нь нийтийн хэв журам сахиулах, өмч хөрөнгө, иргэдийн эрх, эрх чөлөөг гэмт халдлагаас хамгаалах, эрх зүйн зөрчилтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, түүнчлэн гэмт хэргийг илрүүлэхэд идэвхитэй оролцох ажлыг харилцан хамтран хэрэгжүүлэх, цагдаагийн төрөл мэргэжлийн албад, тэдгээрийн хүч хэрэгслийн нийлбэр, цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааны бие даасан нэг төрөл бөгөөд энэхүү алба нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх, нийтийн хэв журам хамгаалах ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж удирдах үүрэг бүхий цагдаагийн байгууллагын мэргэжлийн алба юм.

Нийгмийн хэв журам хамгаалах, нийтийн аюулгүй байдлыг хангах, хууль ёс, эрх зүйн дэг журмыг бэхжүүлэх нь зөвхөн цагдаагийн төдийгүй, төр, олон нийтийн бусад байгууллага, албан тушаалтан, бүх хүнд хамааралтай нийгмийн өргөн хүрээтэй ажил юм.⁸

Гэмт хэрэгтэй тэмцэх, нийгмийн хэв журам хамгаалах үүргийг иргэдтэй хамгийн ойр ажиллаж гүйцэтгэдэг нэгж бол цагдаагийн хэсэг юм.

Иргэд хэсгийн байцаагчийн ажлын ур чадвар, үр дүнгээр нь цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагааг бүхэлд нь үнэлж дүгнэх нь цөөнгүй байдаг бөгөөд нөгөө талаар тэдгээр нь хүн ам, хамт олон, иргэдийг цагдаагийн байгууллагатай холбогч албан тушаалтаны хувьд хэв журмын албанд харъяалагдана.

Цагдаагийн хэсгийн байцаагчийн үйл ажиллагаа нь, цагдаагийн байгууллагын захиргааны үйл ажиллагаанд онцгой байр суурь эзэлнэ. Тэдгээр нь ард иргэдтэй хамгийн ойр дөт байж, тодорхой баг, хороо зэрэг засаг захиргааны нэгж, тодорхой объект хариуцан ажилладаг.

Сүүлийн жилүүдэд гэмт хэрэг, эрх зүйн бусад зөрчил олноор гарч, түүнээс иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид учруулах хохирол нэмэгдсээр байгаа нь гэмт хэрэг, зөрчилтэй хийх тэмцлийг улам хүчтэй болгохын зэрэгцээ шинэлэг арга барилаар ажиллах шаардлага зүй ёсоор гарч байна.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажил нь зардал гаргахгүйгээр үр дүнд хүрэхгүй учир уг ажилд ахиц гаргахын тулд түүнд зохих санхүүжилт шаардлагатай.

Тухайн жилд шүүхийн шийдвэр биелүүлэх, замын хөдөлгөөний болон хэв журмын зөрчлийг арилгах чиглэлээр улсын орлого болгосон торгох ял ноогдуулж, төсөвт тушаасан мөнгөний 40 хувьтай тэнцэх хэмжээний хөрөнгийг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зориулах тухай заалтыг орон нутгийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад зөвөөр ойлгуулж, зохих журмын дагуу гаргуулан авч, оновчтой зарцуулж чадсан эсэхээс ихээхэн зүйл шалтгаална.⁹

Судлаачийн хувьд хэсгийн байцаагчийн үйл ажиллагааны хамгийн үндсэн чиглэл бол урьдчилан сэргийлэх ажил байх ёстой гэж үздэг. Учир нь гэмт хэрэг, эрх зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлыг сайн зохион байгуулснаар тухайн нутаг дэвсгэрийн иргэд, олон нийт амар тайван ажиллаж, амьдрах нөхцөл боломж бүрдэх болно.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг хангах, гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журмыг хамгаалах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор цагдаагийн байгууллагын ажил, үйлчилгээг иргэдэд ойртуулж, гэмт хэрэгтэй тэмцэх, түүнээс урьдчилан сэргийлэх, ажлыг зохион байгуулахдаа иргэд, олон нийтийн санал, санаачлага, тэдний дэмжлэг

⁸ Ж. Долгорсүрэн. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 261 дэх тал

⁹ Г. Даштүдэв. Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын арга зүй". УБ. 2007. 36 дахь тал

туслалцаан дээр тулгуурлаж явуулах шаардлагатай байна.

Үүний зэрэгцээ иргэн нь, оршин суугаа болон ажлын газрынхаа зохиогдож буй эрх зүйн ба хэв журмын зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд оролцоно. Мөн нутаг дэвсгэрийн цагдаагийн байгууллагын энэ чиглэлийн ажилд санаачлагаараа, эсхүл тэдний хүсэлтээр хууль сахиулах ажиллагаанд туслалцаа үзүүлнэ¹⁰ гэсэн заалт ихээхэн хүч дэмжлэг болдог. Харин эрх зүйн боломжийг манай хэсгийн байцаагч нар хэрхэн яаж ашиглахаас хамаарч, урьдчилан сэргийлэх ажлын үр нөлөө тодорхой болдог.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэр дээрээ нэг бүрчилсэн тодорхой арга хэмжээнүүдийг түлхүү зохион байгуулж, аж ахуйн нэгж, байгууллагуудыг камер, дохиолол хамгаалалтын систем суурилуулах, байнгын харуул хамгаалалттай болгох, тэдний сонор сэрэмжийг дээшлүүлэх ажлыг тогтмол зохион байгуулж, заавар зөвлөлгөө өгөх, хяналт шалгалт явуулах ажлыг өнөөг хүртэл хийсэн байна.

Нөгөө талаараа цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын нэг томоохон эх сурвалж бол объектын судалгаа бөгөөд хэсгийн байцаагчийн нутаг дэвсгэрийн судалгаа сайн байж, урьдчилан сэргийлэх ажлын чиглэл гарч ирнэ.

Өнөөдөр хэсгийн байцаагчийн хамгийн түгээмэл хэрэглэгддэг объектын судалгаа бол алба хаагчаас өөрийн ажлын өрөөндөө төрөл бүрийн хэлбэрээр хадгалан байршуулсан цаасан дээр буулгасан тайлан, гэрэлт зураг, газрын зураг, үзүүлэнгийн самбар, компьютерийн лавлагаа болон бүртгэлүүд юм.

Гэмт хэрэг, зөрчлийн тухай мэдээллийг олж авах, баримтжуулан буулгаж авах болон үзүүлэн хийхэд цагдаагийн алба хаагчдаас үүсэл санаачлагатай хандах боломжийг олгож, хөхүүлэн дэмжих шаардлагатай юм. Объектын судалгааны хамгийн гол асуудал бол дэлгэрэнгүй, хамгийн сүүлийн үеийн мэдээ, баримтыг агуулсан хэзээ ч байж байдаг, тогтмол хэрэглэгддэг байх явдал юм. Энэ нь нэг хийгээд болчихдог зүйл биш бөгөөд объектын судалгаагаар байнга баяжуулан шинэчилж, үйл ажиллагаандаа тогтмол ашигладаг байх ёстой.

Цагдаагийн байгууллагын үндсэн мэдээллийн санд хэсгийн байцаагчийн объектын судалгаа чухал үүргийг гүйцэтгэх бөгөөд хариуцсан нутаг дэвсгэрийн онцлог, эрүү болон хэв журмын нөхцөл байдлын талаар судалгаа хийхгүй, мэдэхгүйгээр хэсгийн байцаагчийн ажил, үйлчилгээ иргэдэд үр дүнтэй хүрнэ гэхэд өрөөсгөл юм.

Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэрийн хэмжээ, хил зааг, гудамж талбай, цэцэрлэг, цэнгэлдэх хүрээлэн, үзвэр үйлчилгээний болон олон нийтийн бусад газар, гэр байшин, хашааны эзэмшигч, орох, гарах үүд хаалга, албан газар, байгууллага, дэлгүүр, ресторан, банкны салбар, касс, үнэт материаллын агуулахын байрлал, тэдгээрийн ажиллах цаг, хамгаалалтын байдал, түүнчлэн төр, захиргаа, олон нийтийн байгууллагын хаяг, харилцаахолбоо барих арга, гудамж замын нэвтрэх хэсэг, зогсоол, буудал, тээврийн хэрэгсэл, явган зорчигчдын нягтрал зэргийг урьдчилан судалж нарийн мэдсэн байвал зохино. Хамгийн гол бас нэг зүйл нь өөрийн хэсэгт оршин суугаа хүн амын бүрэлдэхүүн, ажил хөдөлмөр эрхлэлт, орон сууцны нөхцөл, зан заншлын онцлогыг сайтар мэдэх хэрэгтэй.¹¹

Түүнчлэн хэсгийн байцаагчийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлуудын нэг үндсэн хэсэг бол хорих ял эдлээд суллагдсан зарим хүнд тавих захиргааны

¹⁰ Ж. Долгорсүрэн. Монгол улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 262 дох тал

¹¹ Ж. Долгорсүрэн. Монгол Улсын цагдаагийн эрх зүй. УБ. 2004. 114 дэх тал

хяналтын үйл ажиллагаа юм.

Энэ захиргааны хяналтын ажил нь хорих газраас суллагдсан хүмүүсийг дахин гэмт хэрэг, зөрчил үйлдэхээс урьдчилан сэргийлж бүрэн чадахгүй байгаа хэдий ч тухайн иргэнд зөвлөгөө өгөх, анхааруулах, засрал хүмүүжлийн байдалд хяналт тавих, амьдралаа зөв зохиож, хүмүүжих буюу нийгэмшихэд нь тодорхой хэмжээний нөлөө үзүүлэх зэргээр гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчилсэн арга хэмжээний хүрээнд хэрэгжиж байна.

Хэсгийн байцаагч нар ард иргэдтэй хамгийн их ойр дотно байж, байнга тэдний санал хүсэлтийг сонсож, мэдээ мэдээлэл цуглуулан бүртгэл, судалгаандаа тогмол баяжилт хийх, хэсгийн байцаагч нар өөрийн хариуцсан хэсэг, хорооны иргэдийн дунд санал асуулгын хайрцаг явуулж, тэдний санал хүсэлтийг өөрийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгах нь цагдаа-иргэдийн хоорондын хамтын ажиллагаанд дэмжлэг болох болно.

Хэсгийн байцаагч гэдэг албан тушаалтаныг цагдаагийн бусад төрөл мэргэжлийн албан тушаалтнаас доод албан тушаалтан мэт ойлгогдож, бүхий л үйл ажиллагааг хийж, оролцох ёстой мэтээр ханддаг тал бий.

Энэ өрөөсгөл хандлагаас салахад хэсгийн байцаагч нараас өөрсдөөс нь хамгийн их шалтгаална. Учир юу хэмээвээс хэсгийн байцаагч нар мэдлэг боловсрол, ур чадвараа дээшлүүлэх, өндөр мэргэшсэн алба хаагч болохын тулд өөрсдөө идэвхи санаачлагатай ажиллах, иргэдийн дунд нэр хүндээ өргөх ажлыг зохион байгуулж байх, хийсэн ажлаа байнга тогтмол тайлагнаж, бусдаас ур чадвараараа ялгарч байх ёстой.

Тиймээс хэсгийн байцаагчаар ажиллах алба хаагчдын ажиллах нөхцөлийг сайжруулах, мэргэжил, ур чадварыг нь дээшлүүлэх сургалт, семинарт тогтмол хамруулж байх, харилцааны ур чадварыг эзэмшүүлэх, тэргүүний хэсгийн байцаагчийн ажил үүргээ гүйцэтгэж байгаа туршлагаас нь суралцах талаар ажил зохион байгуулах, цагдаагийн байгууллагын төрөл мэргэжлийн албадын дунд “хэсгийн байцаагч” гэдэг албан тушаалтны үнэлэмжийг дээшлүүлэх, цол болон албан тушаалын зэрэглэлийг нэмэх шаардлага зүй ёсоор тавигдаж байна.

Энэ бүхнээс харахад цагдаагийн байгууллагын гэмт хэрэгтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх ажлын гол ачааг нуруундаа үүрч явдаг хүн бол яахын аргагүй хэсгийн байцаагч юм. Хэсгийн байцаагч нь хариуцсан нутаг дэвсгэртээ цагдаагийн чиг үүргийг хэрэгжүүлэхдээ гэмт хэрэг, захиргааны зөрчилтэй тэмцэх, нийтийн хэв журам сахиулах, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг засаг захиргааны анхан шатны нэгж дээр бие даан зохион байгуулж байгаа гол хүч юм.

Тиймдээ ч цагдаагийн байгууллагын гэмт хэргээс урьдчилан ажилд хэсгийн байцаагч нарын явуулж байгаа урьдчилан сэргийлэх ажилд томоохон байр суурь эзэлж байгааг дээрхи бүгдээс дүгнэж байна.